



ҮНДСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас 70-59-24-39 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

САЙХАНОВОО СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
С.АМАРЖАРГАЛ ТАНАА

2017.06.17. № 05752 ҮАГ-НАГ/2017/01-НА /

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын үр дүнд нийцлийн аудит хийх явцад Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 5,000,000.00 /Таван сая/ төгрөгийн өртөгтэй "Сургуулийн оюуны хөгжил төвийн засвар"-ын ажлыг бүртгээгүй, санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д /Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ/, 14.4.2.-т /бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага/, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан "Орон нутгийн хуулийн этгээдийн олж авсан эд хөрөнгийг бүртгэх"-журмын 3 дугаар зүйлийн 3.2-т /Улсын хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан Улсын комисс /Ажлын хэсэг/-ын акт, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн зохих баримт материалыг үндэслэн тухайн төсөл хэрэгжсэн байгууллага нь тайлан балансдаа шууд бүртгэн авна/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг

1301000712

таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. 2017 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайланд “Сургуулийн оюуны хөгжил төвийн засвар”-ын ажлыг бүртгэж, санхүүгийн тайланд тусгах,

2. Албан шаардлагын биелэлтийг 2017 оны 04 дугаар сарын 25-ны дотор аймгийн Аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Сайхановоо сумын Сургуулийн захирал С.Амаржаргал, нягтлан бодогч Г.Бум-аюуш нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН²:

АХЛАХ ШИНЖЭЭЧ

Д.ИХБАЯР

ЗАХИРАЛ

С.АМАРЖАРГАЛ

НЯГТЛАН БОДОГЧ

Г.БУМ-АЮУШ

ЗӨВШӨӨРСӨН:

² Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.